

ТАРААХ МАТЕРИАЛ I:

НҮБУАӨСК-ийн REDD+ хөтөлбөрийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмууд¹

“[REDD+]-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дараах сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг тусган хэрэгжүүлнэ:

a. Тухайн үйл ажиллагаа нь ойн үндэсний хөтөлбөр, холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн зорилгод хувь нэмэр оруулахуйц буюу эсвэл тэдгээрт нийцсэн байна;

b. Хууль эрхзүй, бие даасан байдлыг харгалзан үзсэн ил тод, үр дүнтэй үндэсний ойн засаглалын бүтэцтэй байх;

c. Олон улсын өмнө хүлээсэн үүрэг, үндэсний нөхцөл байдал, хууль тогтоомж, мөн НҮБ-ын Ерөнхий Ассемблейн баталсан Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын Тунхгийг харгалзан үзэж, уугуул иргэдийн болон орон нутгийн нөхөрлөлийн гишүүдийн мэдлэг, эрхийг хүндэтгэх;

d. Оролцогч талууд, тухайлбал, нутгийн иргэд, орон нутгийн иргэдийн бүрэн бөгөөд үр дүнтэй оролцоог хангах;

e. Тэдгээр үйл ажиллагаа нь байгалийн ой, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудалтай нийцсэн байх ба [REDD+] үйл ажиллагааг байгалийн ойг хувиргахад ашиглах бус харин байгалийн ой болон түүнийг экосистемийн үйлчилгээг хамгаалахад чиглэсэн урамшуулал бий болгох, мөн нийгэм, байгаль орчны бусад үр ашгийг сайжруулахад ашигладаг байх

f. Хувирах эрсдлийг тооцох

j. Хүлэмжийн хийн ялгаралт өөр газар шилжих явдлыг бууруулах.

Эх сурвалж: НҮБУАӨСК Шийдвэр 1/CP.16, Хавсралт I, параграф 2

¹ Мөн Канкун сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарим гэж нэрлэдэг, Мексикийн Канкун хотод болсон хурлын үеэр баталсан.

ТАРААХ МАТЕРИАЛ II: СНСЗМС-ИЙН ЗОРИЛГЫН ЖИШЭЭ²

Тэмдэглэл: НҮБҮАӨСК-ийн эхний шаардлага бол REDD+-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад СНСЗ-үүдийг бодлого, хууль, журмуудад хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгааг харуулах. талаар мэдээлэл өгөх систем боловсруулсан байх ёстой” НҮБҮАӨСК-д өргөн барих сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг тусган хэрэгжүүлж байгаа тухай мэдээллийн нэгтгэл нь СНСЗМС-ийн бүтээгдэхүүн болох юм.

Бусад улс орнууд СНСЗМС-ийн нэмэлт, хувилбарт зорилгуудыг тодорхойлсон байна:

1. Хандивлагчид REDD + -ийн бэлэн байдлын болон туршилтын үе шатуудыг санхүүжүүлэхэд нэр хүндийн эрсдэлтэй холбоотой мэдээллээр хангах;
2. REDD + -д үр дүнд суурилсан үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын эрсдэл бага байдгийг харуулах замаар санхүүжилтийг (хувийн болон улсын секторын)татах;
3. REDD+-д үр дүнд суурилсан төлбөр төлөх магадлалтай олон улсын байгууллагуудын шаардлагад нийцүүлэх;
4. Хөдөө орон нутгийн тогтвортой хөгжил, биологийн төрөл зүйлийн хамгаалал зэрэг сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудтай холбоотой хөгжлийн санхүүжилтийн эх үүсвэрийг хүртээмжтэй болгох;
5. одоо байгаа мэдээллийн системийн үйл ажиллагаа, мэдээллийн чанарыг сайжруулах;
6. Илүү байгаль орчинд ээлтэй, тогтвортой, нийгмийн болон жендэрийн тэгш эрхийг хангасан REDD +-ийн үйл ажиллагааг мэдээлэх замаар Үндэсний REDD + Стратегийн хэрэгжилтийг сайжруулах;
7. СНСЗМС-ийн дизайн, үйл ажиллагааны төрөл бүрийн талбарт ороцлогч талуудын тэгш, шадарга оролцоог хангасанаар ил тод байдлыг нэмэгдүүлэр замаар REDD+-ийн үйл ажиллагааг хууль ёсны болгох;
8. ой, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдлийг бууруулах зэрэг төлөр бүрийн салбарт нотолгоонд суурилсан бодлогын шинэчлэл хийхэд хувь нэмэр оруулах;
9. уур амьсгалын өөрчлөлтөөс гадна бусад олон улсын конвенцуудтай нийцэж байгааг харуулах; болон
10. одоо байгаа болон төлөвлөж байгаа мэдээллийн системийн институцийн чадавхийг бэхжүүлэх.

² Өөр бусад REDD+ орнуудаас цуглуулсан